

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН  
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/65/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn

Гэрээт аудитор: Б.Бадамцэцэг

Утас: 70432545

цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын тамгын газар</i>

## Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН .....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН .....	9
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН .....	11
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН .....	12
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН .....	12
3.АУДИТЫН ТАЙЛАН .....	15
3.1. Ерөнхий зүйл .....	15
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	15
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	15
3.4. Материаллаг байдал .....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа .....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
3.0. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	19
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	20

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 978-70433061, Факс: 978-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ЧАНДМАНЬ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Д.ГАНЗОРИГ ТАНАА

2021.02.25 № 4/51  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Чандмань сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чандмань сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга тогилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, төрийн үйлчилгээг ард иргэдэд чанартай, шуурхай хүргэх зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж тогилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

021020365

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Х.БОЛДБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>23,410,672.08</u></b>	<b><u>119,578,721.57</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,726,082.08	95,356,531.57
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	156,785.08	275,471.31
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	309,441.00	309,441.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,259,856.00	94,771,619.26
3351	Байгууллагаас авах авлага	254,777.00	93,766,540.26
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,005,079.00	1,005,079.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	21,684,590.00	24,222,190.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	5,684,590.00	8,222,190.00
35410	Бичиг хэргийн материал	1,258,890.00	1,942,690.00
35420	Аж ахуйн материал	983,700.00	1,540,300.00
35430	Сэлбэг хэрэгсэл	503,000.00	313,000.00
35440	Түлш, шатах тослох материал	819,000.00	839,000.00
35450	Барилгын засварын материал	-	564,050.00
35470	Бусад хангамжийн материал	2,120,000.00	3,023,150.00
35600	Мал амьтад	16,000,000.00	16,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,868,997,814.32</u></b>	<b><u>1,826,767,005.34</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,868,997,814.32	1,826,767,005.34
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,803,861,814.32	1,760,924,213.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,344,170,277.00	1,346,627,277.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(344,952,761.04)	(395,391,768.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	177,131,900.00	177,131,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(62,634,079.59)	(79,752,879.63)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	167,471,777.00	171,873,313.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(126,344,080.62)	(135,342,520.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,718,883.50	41,622,483.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(19,565,937.50)	(21,622,969.90)
39209	Зам, гүүрийн байгууламж	542,380,223.00	542,380,223.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(98,371,648.00)	(100,632,376.00)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	35,450,000.00	35,450,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	206,028,707.00	239,468,707.00

39215	Хуримтлагдсан элэгдэл	(50,777,346.43)	(62,043,075.38)
39217	Ном	1,155,900.00	1,155,900.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>65,136,000.00</b>	<b>65,842,791.59</b>
39301	Програм хангамж	2,463,500.00	3,493,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,256,500.00)	(1,579,708.41)
39303	Бусад биет бус хөрөнгө	63,929,000.00	63,929,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,892,408,486.40</u></b>	<b><u>1,946,345,726.91</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>2,758,629.00</u></b>	<b><u>683,258.78</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,758,629.00	683,258.78
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,758,629.00	683,258.78
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	18,629.00	683,258.78
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,740,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	2,740,000.00	-
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,889,649,857.40</u></b>	<b><u>1,945,662,468.13</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,889,649,857.40	1,945,662,468.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	824,123,118.24	824,123,118.24
51101	Өмч: - төрийн	824,123,118.24	824,123,118.24
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	809,844,231.09	865,856,841.82
51210	Өмнөх үеийн үр дүн	809,844,231.09	815,041,231.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	50,815,610.73
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	255,682,508.07	255,682,508.07
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,892,408,486.40</u></b>	<b><u>1,946,345,726.91</u></b>

## 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>935,411,423.00</b>	<b>656,902,047.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>490,038,142.00</b>	<b>18,918,400.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	490,038,142.00	18,918,400.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	490,038,142.00	18,418,400.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	849,900.00	988,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	489,188,242.00	17,429,900.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал		500,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>445,373,281.00</b>	<b>637,983,647.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	103,209,581.00	251,743,447.00

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,701,440.00	44,196,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,472,141.00	206,111,947.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,036,000.00	1,435,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>342,163,700.00</b>	<b>386,240,200.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	315,799,000.00	368,380,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	26,364,700.00	17,860,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>426,695,249.94</b>	<b>599,086,436.25</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>425,952,749.94</b>	<b>599,086,436.25</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>424,158,409.94</b>	<b>576,602,456.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>216,347,595.00</b>	<b>254,798,540.00</b>
210101	Үндсэн цалин	167,642,210.00	190,785,469.00
210102	Нэмэгдэл	40,677,765.00	58,013,071.00
210104	Урамшуулал	1,995,120.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	6,032,500.00	6,000,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>26,666,671.92</b>	<b>31,190,580.29</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,152,920.92	21,254,975.93
210202	Тэтгэмжийн даатгал	2,135,637.75	5,777,114.72
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,700,830.20	1,993,748.31
210204	Ажилгүйдлийн даатгал	425,207.55	494,660.97
210205	Эрүүл мэндийн даатгал	4,252,075.50	1,670,080.36
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>15,483,000.00</b>	<b>17,783,077.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,485,000.00	1,352,577.00
210302	Түлш, халаалт	13,998,000.00	16,430,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,981,097.00</b>	<b>24,082,578.50</b>
210401	Бичиг хэрэг	3,068,406.00	2,489,500.00
210402	Тээвэр, шатахуун	19,990,791.00	18,761,242.50

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,141,000.00	2,831,836.00
210404	Ном, хэвлэл	780,900.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>385,000.00</b>	<b>299,100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	385,000.00	299,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,535,099.00</b>	<b>2,056,150.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	102,500.00	42,500.00
210604	Урсгал засвар	3,432,599.00	2,013,650.00
<b>21 07</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,865,700.00</b>	<b>3,263,840.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,865,700.00	3,263,840.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,034,515.00</b>	<b>24,267,798.20</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,284,046.00	21,683,595.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	355,000.00	324,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	1,550,160.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	221,450.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	22,793.20
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	318,800.00
210807	Газрын төлбөр	75,469.00	147,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>97,859,732.02</b>	<b>218,860,792.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,804,675.54	125,293,083.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,055,056.48	93,567,708.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,794,340.00</b>	<b>22,483,980.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,434,440.00</b>	<b>20,139,380.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	18,480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,434,440.00	1,659,380.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>359,900.00</b>	<b>2,344,600.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	359,900.00	2,344,600.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>742,500.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>742,500.00</b>	<b>-</b>

223001	Бусад хөрөнгө	742,500.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>508,716,173.06</b>	<b>57,815,610.75</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	67,312,609.22	7,000,000.02
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	67,312,609.22	7,000,000.02
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(67,312,609.22)	(7,000,000.02)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>441,403,563.84</b>	<b>50,815,610.73</b>

### 2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>446,223,181.00</b>	<b>638,972,147.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>849,900.00</b>	<b>988,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	849,900.00	988,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	849,900.00	988,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	849,900.00	988,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>445,373,281.00</b>	<b>637,983,647.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	103,209,581.00	251,743,447.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	95,701,440.00	44,196,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,472,141.00	206,111,947.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,036,000.00	1,435,000.00
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	342,163,700.00	386,240,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	315,799,000.00	368,380,200.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	26,364,700.00	17,860,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>355,401,741.00</b>	<b>604,135,147.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>355,401,741.00</b>	<b>604,135,147.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>353,653,241.00</b>	<b>581,730,547.00</b>

<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	214,117,278.00	249,653,117.00
210101	Үндсэн цалин	141,900,300.00	189,185,387.05
210102	Нэмэгдэл	36,607,078.00	44,108,649.76
210105	Гэрээт ажлын хөлс	35,609,900.00	16,359,080.19
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,992,122.00	35,632,483.00
210201	Тэтгэврийн даатгал	18,508,122.00	25,606,483.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,121,100.00	2,506,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,696,800.00	2,005,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	424,200.00	501,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,241,900.00	5,012,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	13,539,000.00	18,480,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,985,000.00	2,030,000.00
210302	Түлш, халаалт	11,554,000.00	16,450,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	24,797,000.00	21,402,500.00
210401	Бичиг хэрэг	3,843,600.00	3,534,900.00
210402	Тээвэр, шатахуун	17,352,300.00	14,594,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,821,000.00	3,272,800.00
210404	Ном, хэвлэл	780,100.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	402,000.00	402,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000.00	402,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,343,600.00	2,342,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000.00	200,000.00
210604	Урсгал засвар	4,143,600.00	2,142,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,735,700.00	4,849,000.00
210702	Дотоод албан томилолт	7,735,700.00	4,849,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	30,334,700.00	25,106,776.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,369,700.00	24,254,776.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000.00	260,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000.00	290,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,000.00	125,000.00
210807	Газрын төлбөр	138,000.00	147,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>31,391,841.00</b>	<b>223,861,571.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,391,841.00	223,861,571.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,748,500.00</b>	<b>22,404,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,388,600.00</b>	<b>20,060,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	18,480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,388,600.00	1,580,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>359,900.00</b>	<b>2,344,600.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	359,900.00	2,344,600.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>90,821,440.00</u></b>	<b><u>34,837,000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>90,821,440.00</b>	<b>34,837,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>90,821,440.00</b>	<b>34,837,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>90,821,440.00</b>	<b>34,837,000.00</b>
223001	Бусад хөрөнгө	90,821,440.00	34,837,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(90,821,440.00)</u></b>	<b><u>(34,837,000.00)</u></b>

#### 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	824,123,118.24	255,732,730.60	352,390,444.72	1,432,246,293.56
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	50,222.53	50,222.53
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	824,123,118.24	255,732,730.60	352,440,667.25	1,432,296,516.09

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(50,222.53)	-	(50,222.53)
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	457,403,563.84	457,403,563.84
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>824,123,118.24</b>	<b>255,682,508.07</b>	<b>809,844,231.09</b>	1,889,649,857.40
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>824,123,118.24</b>	<b>255,682,508.07</b>	<b>809,844,231.09</b>	1,889,649,857.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,197,000.00	5,197,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	824,123,118.24	255,682,508.07	815,041,231.09	1,894,846,857.40
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	50,815,610.73	50,815,610.73
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>824,123,118.24</b>	<b>255,682,508.07</b>	<b>865,856,841.82</b>	1,945,662,468.13

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	387326100.00	384884100.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	387,326,100	384,734,100
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	367,266,100	364,674,100
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	250,648,100	249,653,117
210101	Үндсэн цалин	171,636,700	189,185,387
210102	Нэмэгдэл	51,819,400	44,108,650
210105	Гэрээт ажлын хөлс	27,192,000	16,359,080
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	33,837,500	35,632,483
210201	Тэтгэврийн даатгал	23,811,500	25,606,483
210202	Тэтгэмжийн даатгал	2,506,500	2,506,500
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,005,500	2,005,500
210204	Ажилгүйдлийн даатгал	501,500	501,500
210205	Эрүүл мэндийн даатгал	5,012,500	5,012,500
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	18,480,500	18,480,500
210301	Гэрэл, цахилгаан	2,030,000	2,030,000

210302	Түлш, халаалт	16,450,500	16,450,500
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,117,500	20,967,500
210401	Бичиг хэрэг	3,249,900	3,099,900
210402	Тээвэр, шатахуун	14,594,800	14,594,800
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,272,800	3,272,800
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	402,000	402,000
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	402,000	402,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,163,600	2,342,600
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	200,000	200,000
210604	Урсгал засвар	2,963,600	2,142,600
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	6,742,400	4,849,000
210702	Дотоод албан томилолт	6,742,400	4,849,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	21,440,300	21,112,700
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,288,300	20,260,700
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	260,000	260,000
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,000	290,000
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000	30,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	425,000	125,000
210807	Газрын төлбөр	147,000	147,000
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	11,434,200	11,234,200
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,434,200	11,234,200
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	20,060,000	20,060,000
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	20,060,000	20,060,000
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,480,000	18,480,000
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,580,000	1,580,000
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>150,000</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	150,000
223001	Бусад хөрөнгө	-	150,000

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	387,326,100	384,884,100
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	386,721,100	383,895,600
132001	Орон нутгийн төсвөөс	368,861,100	366,035,600
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	17,860,000	17,860,000
<b>1E+05</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	605,000	988,500
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	605,000	988,500
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	23	23
620001	Удирдах ажилтан	9	9
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9
620003	Үйлчлэх ажилтан	3	3
620004	Гэрээт ажилтан	2	2
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>23</b>	<b>23</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	8	8
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5
650010	Гэрээт ажилтан	2	2
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	8	8

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>251,743,447.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>217,056,447.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	217,056,447.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	435,000.00
210401	Бичиг хэрэг	435,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,994,076.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,994,076.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	212,627,371.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	212,627,371.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,687,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	34,687,000.00
223001	Бусад хөрөнгө	34,687,000.00

<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	251,743,447.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	251,743,447.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	44,196,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	206,111,947.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,435,000.00

### **3.АУДИТЫН ТАЙЛАН**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Тамгын газрын дарга Д.Ганзоригт танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд байгууллагын анхан шатны баримтын бүрдэл, авлага барагдуулах, шилэн дансны мэдээллийн талаар менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дүгээр сарын 20-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ний хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор Б.Бадамцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын “Иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай, хүртээмжтэй хүргэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг орон нутагт хангуулах” гэсэн эрхэм зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Чандмань сумын Засаг даргын Тамгын газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар 2020 онд тус байгууллагад дотоод хяналт хийгдээгүй байна. Харин сумын санхүүгийн албанаас төрийн сангийн хяналтыг тухай бүр хэрэгжүүлсэн боловч төрийн сангийн хяналт сул хангалтгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 952396.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 9523.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 656902.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 6569.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 51481,1 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
АВЛАГА	1726.1	95356,5	93630.4
БАРАА МАТЕРИАЛ	21684.5	24222.2	2537.6
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1868997.8	1824310.8	-44686.9
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1892408.5</b>	<b>1943889.5</b>	<b>51481.1</b>
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2758.6	683,2	(2075.4)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1889649.8	1943206,3	53556.5
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1892408.5</b>	<b>1943889,5</b>	<b>51481.1</b>

Оны эхэнд 1726.1 мянган төгрөгийн авлага байснаас 95356.5 мянган төгрөг болж 93630.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэмэлт дансны ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Сумын төвийн гэр хороололд хүүхэд залуучуудын чөлөөт амралтын талбай байгуулах ХОАОНӨГ/202001148 гэрээт ажлыг Элгэн итгэл сэтгэл ХХК гүйцэтгэсэн боловч ажлын гүйцэтгэлийн, явцын анхан шатны баримтын бүрдэл хангаагүй шууд санхүүжилт олгосон, ажлыг ашиглалтад хүлээлгэн өгөх комисс ажиллаагүй, хүлээж аваагүйтэй холбоотой 71779.3 мянган төгрөг, мөн Чандмань сумын иргэн М.Жанчивдулам 2020 оны 04 дүгээр сарын 06-нд 01 тоот гэрээ байгуулан Жаргалант багийн нутаг Хуурай харгана гэдэг газрын богино яндант худгийг засварлах ажлыг хугацаандаа гүйцэтгээгүй, гэрээг ковидтэй холбоотой сунгасан 1890.0 мянган төгрөг, Тэмүүлэх гал ХХК нь 2020 оны 06-р сарын 03-нд ХОАОНӨГ/202001065 тоот гэрээгээр Чандмань сумын сүлжээ багт моторт завь нийлүүлэх гэрээ хэрэгжээгүй, урьдчилгаа 20000.0 мянган төгрөгийн санхүүжилт хийгдсэн нь ковид цар тахалтай холбоотой 2021 он гарч нийлүүлэгдэж байгаатай холбоотойгоор авлага өссөн байна. Өмнөх оны авлагаас 1471.3 мянган төгрөгийн авлага

барагдаагүй байгаа нь он дамжсан насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь тодорхой бус, баримтуудыг урьд онууд руу хөөн шалгахад нотлогдохгүй байгаа зэргээс үүдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24222.1 мянган төгрөг болж 2537.6 төгрөгөөр өссөн нь тайланд онд ковид 19 холбогдуулан ариутгалын бодис болон бусад хангамжийн материал нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2572900.2 мянган төгрөг, оны эцэст 2621405.3 мянган төгрөг болж 58336.9 мянган төгрөгөөр өсөж 1104,8 мянган төгрөгийн хөрөнгө акталж өмнөх оны 8726,1 мянган төгрөгийн хөрөнгийн залруулга хийсэн байна.

Энэ нь тайлант онд улсын төсөв болон ОНХСангаар хийгдсэн 7027.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2490.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 31240.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, худалдан авсан 150,0, үнэ төлбөргүй 17429.9, нийт 58336.9 мянган төгрөгөөр нэмэгджээ.

Нийт зардал өмнөх оноос 173120,3 мянган төгрөг буюу 40.6 хувиар өссөн нь цалин, шимтгэлийн зардал 42974.8 мянган төгрөг буюу 58.4 хувь, тогтмол зардал 2300.0 мянган төгрөг буюу 11,5 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 109140.6 мянган төгрөг буюу 60.2 хувь, тэтгэвэрт гарахад тэтгэмж 18704.9 мянган төгрөг буюу 40.3 хувиар өссөн, хангамж бараа материалын зардал 2898,5 мянган төгрөг буюу 10.7 хувь, нормативд зардал нь 85,9 мянган төгрөг буюу 22,3 хувь, томилолт 4601,8 төгрөг 58,1 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн 4766.7 мянган төгрөг буюу 14.4 хувь, эд хогшил 1478.9 мянган төгрөг буюу 41.8 хувиар буурсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт.**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 396265.0 мянган төгрөгөөр үндсэн үйл ажиллагааны орлого 605.0 мянган төгрөг нийт 396870.0 мянган төгрөгөөр нийт зардлыг 396870.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл:**

Тайлан онд орон нутгийн 368380.2 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн хөгжлийн сангаас 17860.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 988.5 мянган төгрөг төвлөрүүлж нийт 387228.7 мянган төгрөг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс нийт 368380.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, 2344.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **Нэмэлт санхүүжилт:**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 251743.4 мянган төгрөг төвлөрснөөс мал тооллого, хүн амын тооллогын зардалд 4930.6 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 200965.3 мянган төгрөг, Хөшөөт хөгжлийн сангаас 39000.0 мянган төгрөг, тендерийн 1435.0 мянган төгрөг, ХХҮГ-аас 2000.0 мянган төгрөг, Аймгийн ЗДТГ-аас 3196.5 мянган төгрөг, ОБГ-аас 216.0 мянган төгрөг тус тус орж батлагдсан арга хэмжээний зардалд зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлого, зарлагын 31 гүйлгээ, нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмжийн хэрэгжилт 80 хувьтай байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 59426.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 31841.6 мянган төгрөгийг залруулж, 358.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 20148.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага, 7078.8 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа 31841.6 мянган төгрөгийн алдааг асуудлын бүртгэлээр танилцуулж, албан тоотоор залруулга хийлээ.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 52347.8 мянган төгрөгийн алдаа илэрч 31841.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, залруулагдаагүй 20506.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 358,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 20148.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага бичиж хүргүүлээ.

1. Жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагадсан, шатахуун олгох зөвшөөрлийн бичиг дугааргүй, дарга нар олгодог, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй 20148.2 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 6.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20-р зүйлийн 20.2.5 дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх, ...тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д "Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д "Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн хуулийн заалтууд, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Томилолтын зардлыг олгохдоо томилолтоор ажиллах удирдамж батлуулаагүй, томилолт давхардуулан илүү олгосон, Тамгын газрын даргын 2020 оны А/26, А/30 тоот тушаалуудаар мөнгө олгохдоо нярвын дансанд шилжүүлж, зарцуулалтыг тайлагнаагүй,

олгосноо баталгаажуулаагүй, түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо ашгийн татвар суутгаагүй зэрэгтэй холбоотой 358.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" хуулийн заалтууд, "Үнэн зөв байдал", "Иж бүрэн" байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

### **3.0. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **1. Анхан шатны баримттай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Тайлант онд ЗДТГ-ын харилцахаар гарсан гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэр интернетийн үйлчилгээний гэрээгүй, ашиглалт тодорхой бус, хувь хүний нэр дээр гэрээтэй, түлээ нүүрсний хөнгөлөлт, үр дүнгийн урамшуулал олгохдоо Сангийн яамны нэгдсэн цалингийн Payroll программаар дамжуулаагүй 5607.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Эрсдэл: Төсвийн хөрөнгийн үр өгөөж буурах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

1.3 Өгсөн зөвлөмж нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7-дахь заалтыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

### **2. Авлагатай холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Хариуцах эзэн холбогдогч тодорхой бус хувь хүмүүстэй холбоотой 1471.3 мянган төгрөгийн авлага үүсэж, барагдахгүй байгаа нь насжсан авлагын ангилалд орж байгаа бөгөөд энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20-р зүйлийн 20.2.5-д " дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр

тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх,...тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**2.2 Эрсдэл:** Хөрөнгийн үр өгөөж буурах

**2.3 Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах, эзэн холбогдогчийг тогтоож шийдвэрлэх

**2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

**3. Шилэн данстай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Шилэн дансны хуульд заасан цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлага, холбогдох мэдээллийг мэдээлээгүй, нэмэлт санхүүжилтийн орлого, зарлагын ажил гүйлгээг байршуулаагүй байна.

**3.2. Эрсдэл:** Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлэхгүй байх, хуулийн заалтыг мөрдөөгүй байх

**3.3. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” мэдээлэх гэсэн заалтуудыг мөрдөн холбогдох мэдээллийг тухай бүрд мэдээлж хэвших.

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо: 2021

Аудитын нэр: Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ХОА-2021/65/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр: Чандмань сумын Засаг даргын Тамгын газар

Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант үеийн үр дүн зөрүүтэй илэрхийлсэн	19144.6	Залруулга	Дарга Ня-бо	Д.Ганзориг Ү.Тунгалагбаяр
2	ОНХС-ийн орлогыг үнийн зөрүүтэй орлогодсон, Төрийн сангийн суутган үлдсэн 5 хувийн барьцааг өглөгөөр тусгасан байсныг өмнөх үр дүн лүү залруулсан	5197.0	Залруулга		

3	Тайлант онд зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгийг орлого авсныг залруулах	7000.0	Залруулга		
4	Сумын Уяачдын холбооноос Ковид-19 цар тахалтай холбоотой албан хаагчдад нэг удаагийн хамгаалах хэрэгсэл, маскийг үнэ төлбөргүй өгснийг үнэ төлбөргүй орлогоор бүртгээгүй орхигдуулсан	500,0	Залруулга		
5	Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй	0	Зөвлөмж өгөх		
6	Жолоочийн тооцоо бодоогүй, тооцооны хуудас бичигдээгүй, спидометрийн заалт баримтлаагүй шатахуун зарлагадсан, шатахуун олгох зөвшөөрлийн бичгийг дарга нар олгодог, шатахууны зарцуулалтад тавих хяналт сул, дотоод хяналт хэрэгжүүлээгүй	20148.2	Албан шаардлага		
7	Томилолтын зардлыг олгохдоо томилолтоор ажиллах удирдамж батлуулаагүй, томилолт давхардуулан илүү олгосон, Тамгын газрын даргын 2020 оны А/26, А/30 тоот тушаалуудаар мөнгө олгохдоо нярвын дансанд шилжүүлж, зарцуулалтыг тайлагнаагүй, олгосноо баталгаажуулаагүй, түлээ нүүрсний хөнгөлөлт олгохдоо ашгийн татвар суутгаагүй	358.0	Төлбөрийн акт		
8	Тайлант онд ЗДТГ-ын харилцахаар гарсан гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэр интернэтийн үйлчилгээний гэрээгүй, ашиглалт тодорхой бус, хувь хүний нэр дээр гэрээтэй, түлээ нүүрсний хөнгөлөлт, үр дүнгийн урамшуулал олгохдоо Сангийн яамны нэгдсэн цалингийн Payroll программаар дамжуулаагүй 5607.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.	5607.5	Зөвлөмж өгөх		
9	Хариуцах эзэн холбогдогч тодорхой бус хувь хүмүүстэй холбоотой авлага үүсгэсэн.	1471.3	Зөвлөмж өгөх		
<b>Дүн</b>		<b>59426,6</b>			

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР